



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 19 өдөр

Дугаар А/111

Бор-Өндөр сум


**Харгалзан дэмжигчээр тогтоох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гэр бүлийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 67 дугаар зүйлийн 67.1.1 дэх заалт, 64 дүгээр зүйлийн 64.1.1 дэх заалт, 65 дугаар зүйлийн 65.1 дэх хэсэг, 71 дүгээр зүйлийн 71.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Бор-Өндөр сумын Бумбат 3 дугаар багийн Дэнж 7-712 тоотод оршин суугч Бат-Эрдэнийн Саранзаяагийн төрсөн эцэг Очирбатын Бат-Эрдэнэ нь 2022 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр нас барсан, төрсөн эх нь бага байхад нь хаяж явсан тул түүний авга эгч Очирбатын Ганхөлөгийг харгалзан дэмжигчээр тогтоосугай.

2. Харгалзан дэмжлэгт байгаа Б.Саранзаяад хувийн хэрэг нээж, харгалзан дэмжих гэрээг О.Ганхөлөгтэй байгуулан, жил бүр дүгнэж ажиллахыг Нийгмийн бодлогын мэргэжилтэн (Ц.Эсүжин)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.АДЪЯАБИЛЭГТ